

## МОНГОЛ ҮНДЭСТНИЙ БИЧИГ ҮСГИЙН ГОО ЗҮЙ

Жилээ, магистр, ӨМБИС

### Abstract

Nationality of Mongolia is one of nationalities existing at the Northern Asia and it is central nationality of Mongolia. Nationality of Mongolia has long periodic history and rich of heritage of culture and education. Nationality of Mongolia has its own language and peculiar script. As much as script and language of the nationality of Mongolia is being transformed and changed according to the historical flow, it has a history that it is being adapted in certain condition. Uighar Mongolian script is well-known in the world and it has its own feature because it was the state script of the Nationality of Mongolia. Nationality of Mongolia respects and considers as superior its script, culture and traditions. It is attracting the world community as it reached the perfect level among the historical reform having its esthetic feature. Within my chosen thesis, I researched the structure, position, drawing, internal meaning of the Uighar Mongolian script for the esthetic feature of script of the Nationality of Mongolia and aimed to consider as important the development of the script of the nationality, further storage & development of the script of the nationality for the globalized current exchange of the culture and social relations.

### Түлхүүр үг

Бичиг үсэг, монгол үндэстэн, урлаг, чимэглэл, дизайн, өв уламжлал, үндэсний соёл

### Удиртгал

Ази тивийн төвд орших Монгол үндэстэн нь урт удаан жилийн түүхтэй, соёл боловсролын агуу баялаг өвтэй билээ. Монгол үндэстэн нь өөрийн гэсэн үг хэл, өвөрмөц бичиг үсгийн олон зууны гайхамшигт соёлтой. Монгол үндэстний бичиг үсэг нь түүхийн явцад хувьсан өөрчлөгдөхийн хамт тухайн байдалдаа зохицсон түүхийг ч мөн өгүүлж байдаг. Дэлхийд гайхагдсан Уйгаржин монгол үсэг нь монгол үндэстний төрийн бичиг болсны хувьд өөрийн гэсэн өвөрмөц онцлог, түүхийг илтгэж ирсэн байдаг. Монгол үндэстэн бол бичиг соёл өв уламжлалаа дээдэлдэг үндэстэн билээ. Тэдний бичиг, үсэг нь өөрийн гоо сайхны өвөрмөц онцлогтой байж түүхэн өөрчлөлтийн дунд улам боловсронгуй түвшинд хүрч дэлхий нийтийн сонирхлыг татсаар иржээ. Энэхүү сонгосон сэдвийн хүрээнд миний бие монгол үндэстний бичиг үсгийн гоо сайхны онцлогийн хувьд уйгаржин монгол үсгийн бүтэц, байршил, бичлэг, зурлага, үсгийн дотоод утга зэргийн талаар судалж, үндэстний үсэг бичгийн өрнөл, хөгжил, даяарчилсан одоо үеийн соёлын солилцоо ба нийгмийн харилцаанд үндэстний үсэг бичгийн онцлогоо хойшид хадгалж явахын зайлшгүй чухлыг онцлохыг зорилгоо.

### Үндсэн хэсэг

#### *Монгол үндэстний үсэг бичгийн түүхэн хөгжил*


Тухайн үндэстний соёлыг нэгэн бүхэл систем гэж үзэж болно. Үг хэл, үсэг бичиг нь энэхүү бүхэл системийн бүрэлдэхүүний чухал нэг хэсэг юм. Мөн энэ системийн нэгэн чухал зууч үг хэл, үсэг бичиг нь өөрийн онцлог болон

шинж чанараараа тухайн үндэстний түүх соёлыг дамжуулан уламжилж байдаг. Азийн үндэстний үг хэл, үсэг бичиг нь хоорондоо харилцан адилгүй байдаг бөгөөд тухайн үндэстнийхээ өв соёлын хэвшлийг тусгаж байдаг. Монгол бичиг үсгийн хөгжил, хувьсал нь ерөнхийдөө доорх хэдэн үе шатанд хуваагдана.

1. Уйгаржин монгол үсэг: XII зуунаас XVI зууны сүүлч хүртэл энэхүү үсгийг хэрэглэж байв. Монголчууд уйгаржин үсгийн суурин дээр уйгаржин монгол үсгийг шинэчлэн зохиосон байна. Иймээс уйгаржин монгол үсгийн зөв бичгийн зарим дүрэм нь шууд уйгар үсгээс уламжлагдсан байдаг. XVI-XVII зуунд энэхүү үсэг бичиг нь цаг үеийн өөрчлөлтийг заасан орчин үеийн монгол хэл болон хувирч, одоо хэрэглэж байгаа уламжлалт монгол үсгийн үндсэн бичиг болжээ.

#### Зураг 1

Уйгаржин монгол үсэг (“Эрдэнийн эрх ба ноёдын өргөмжлөл” дэвтэрлэсэн судраас)



Эх сурвалж: *The Mongolian Calligraphy 1*, Батбаяр Жалайр, 2015, х.56.

Уйгаржин монгол үсгийн дээрээс доош холбон бичиж, зүүнээс баруун хойш мөр шилждэг өвөрмөц онцлог болон дүрслэлийн гоо зүйг 1-р зургаар (Батбаяр Жалайр, Д. Монгол уран бичлэгийн түүх. УБ 2015) үзүүлээ.

2. Дөрвөлжин үсэг: Пагва үсгийг мөн дөрвөлжин үсэг гэж нэрлэдэг. Энэхүү үсгийг Юань гүрний үед хааны багш Төвдийн буддын шашны Сажа бүлгийн удирдагч Пагва бүтээжээ. Энэхүү үсэг нь төв үсгээс үүссэн авиачилсан үсэг юм. Пагва үсгийн хөгжин, дэлгэрэх хугацаа нь харьцангуй бага учраас хэдийгээр хуучнаар баталгаажсан төрийн үсэг байсан ч эцэстээ дэлгэрүүлж хэрэглэхэд бэрхшээл учирч улмаар Юань гүрний дараа аажмаар устжээ.

Дөрвөлжин үсгийн цагаан толгойн бичлэгийг 2-р зургаар үзүүлээ.

Зураг 2

Хэвтээ дөрвөлжин үсгийн цагаан толгой




Эх сурвалж: Эх сурвалж: *The Mongolian Calligraphy 1*. Батбаяр Жалайр, 2015, х.47.

3. Тод үсэг: 1648 онд Ойрдын Зая Бандид Огторгуйн далай Намхайжамц бүтээсэн үсэг юм. Энэхүү үсгийг Ойрдууд голчлон дунд хэрэглэж байв. Энэ үсэг нь монгол үсгийн дундах зарим ялгаж дийлэхгүй авиаж ялгаж, зарим бичлэгийн аргыг дүрслэх чанар, ярианы хэллэгийн хэлбэрт оруулжээ. Гэтэл эдгээр өөрчлөлтийн олонх нь Ойрд нутгийн аялгад суурьшсанаас тод үсэг нь бусад нутгийн аялгатай зөрөх тул өргөн дэлгэрч чадсангүй. Тод үсгийг 3-р зургаар үзүүлээ.

Зураг 3

Тод үсгийн судрын хуудас



Эх сурвалж: *The Mongolian Calligraphy 1*, Батбаяр Жалайр, 2015, х.42.

4. Соёмбо үсэг: 1686 онд анхдугаар Богд Занабазар үүсгэж бүтээсэн. Энэ үсэг нь Санскрит хэлний ланз-хэлбэрээс үүсэлтэй. Гол нь шашны ёс жаяг, засал чимэглэлийн үйлд хэрэглэдэг байжээ. Энэхүү үсгийн бичлэг нь түгээмэл бус байснаас ардын дархчууд өргөн хэрэглэж байсангүй.

Зураг 4

Соёмбо үсгийн цагаан толгой



Эх сурвалж: (*The Mongolian Calligraphy 1* . Батбаяр Жалайр, 2015, х.44).

5. Вагиндра үсэг: 1905 онд Буриадын лам Агваандорж үүсгэн бүтээжээ. Энэхүү үсэг нь голдуу буриад нутгийн аялгыг нэгтгэдэг бөгөөд 100 гаруй цагаан толгойн тэмдэглээтэй, шашин суртахууны хүрээнд хэрэглэгдэж байгаад цаашид дэлгэрүүлж хэрэглэсэнгүй. “Вагиндра шинэ хуучин үсэг тэргүүтний бичсэн дэвтэр”, “Бурхан багшийн хураангуй намтар”, “Буянт хан хөвгүүний намтар оршив” зэрэг ном товхимлыг барласнаас цааш түгэн тархаагүй байна.

Зураг 5

Вагиндра цагаан толгойн үсэг



Эх сурвалж: <http://www.munkho.de/wp/монгол-бичгийн-соёл-түүх-уран-бичлэг-6-2/>

6. Кирил монгол үсэг: Сэлбэ монгол үсэг гэдэг. 1930-1940 оны хооронд Монгол улсын бичиг үсэг, монгол хэлэнд өөрчлөлт хийж латин цагаан толгойд тулгуурласан Монгол үсгийг зохион, 1942 оноос эхлэн туршин хэрэглэж байв. Улмаар 1946 оноос албан ёсоор хэрэглэхээр болсон боловч удалгүй хэрэглэхээ больсон байна. Дараа нь дахин кирил цагаан толгойгоор аялгыг авиалж бичихийг улсын хуулиар бататгаж, төрийн хэл болгожээ. Ингэснээр уламжлалт уйгаржин үсэг нь өдөр тутмын хэрэглээнээс аажмаар гарсан. Кирил монгол үсэг нь зүүнээс баруун тийш, хэвтээгээр бичиж, ном бичгийн барлах болон шинжлэх ухааны бичиг сударт хэрэглэхэд дөхөм болсон боловч уламжлалт уйгаржин монгол үсэгтэй харьцуулахад бичихэд хурдан, олон аймгийн нутгийн аялгыг шингээж чаддаг зэрэг давуу талаа алдсан юм.

### Зураг 6

Кирил үсгийн цагаан толгой

А,Б,В,Г,Д,Е,Ё,Ж,З,И,Й  
К,Л,М,Н,О,Ө,П,Р,С,Т  
У,Ү,Ф,Х,Ц,Ч,Ш,Щ,Ъ,Ь,  
Ы,Э,Ю,Я

Эх сурвалж: <http://www.munkho.de/wp/монгол-бичгийн-соёл-түүх-уран-бичлэг-6-2/>

Энэхүү кирил үсэг нь хэвтээгээр зүүнээс баруун тийш бичиж, дээрээс доошоо мөр шилждэг онцлогтой үсэг юм.

### Монгол үндэсний үсэг бичгийн гоо сайхны зүй дэх урлагийн хөгжилт

Монгол үндэсний соёл нь тал нутгийн, европ, өрнө дахины, ази дорно дахины соёлуудын хоорондоо идэвхжиж, солилцсон олон үндэстний онцлог хэлбэртэй юм. Мөн үндэсний олон шүтээнтэй шашны үүднээс хатан зоригт эрэлхэг баатрууд нь гоо сайхан, үзэл ухамсрын гол байрыг эзэлж байгааг ойлгож болно.

Монгол үндэсний энэхүү гоо сайхны үзэл, ухаан нь үндэсний бичгийн хэрэглэгдэх чанарт нөлөөлсөн нь тодорхой байна.

-Уйгаржин монгол бичгийн үндэсний онцлог бол дээрээс доош холбон бичиж, нэг үг нь нэгж байж, зүүнээс баруун хойш мөр шилжиж бичдэг бол кирил үсэг нь орос үсгээс суурилж хэвтээгээр зүүнээс баруун тийш бичиж, дээрээс доошоо мөр шилжих онцлогтой.

-Уйгаржин монгол бичигт бичих багаж хэрэгсэл олон байдаг. Одоо үеийн шинэчлэгдсэн багажаас

гадна, урт бичлэг ба урлаг үсэгт хэрэглэгддэг хулсан үсэг болон үсэн бийр байдаг. Хулсан үзгийг ерөнхийдөө хулс, мод, дэрс, яс зэрэг байгалийн түүхий эдээр шууд хийдэг. Хулсан үзгийн үзүүр нь ташуу хэлбэртэй байдаг. Хулсан бийрийг хатуу чанартай материалаар хийдэг ба үзүүр нь өвөрмөц онцгой хэлбэртэй.

Хулсан үзгээр бичсэн үсгийн нуруу нь өргөн бусад зурлага нь олон зүйлийн хувилбартай байдаг ба этгээд гоё сайхан дүрстэй харагддаг. Үсэн бийрийг хэрэглэх нь Хятадын соёлоос уламжлагдаж ирсэн түүхтэй. Одоогийн маш олон уран бичлэг нь бүгд үсэн бийрээр бичигдсэн байдаг. Юань гүрний үеийн нийгмийн байдлыг харуулсан материал цөөхөн боловч, одоогийн илрүүлсэн түүхийн зарим дурсгалт эд зүйлсээс үзэхэд монгол үсгийн хөгжил дэх дөрвөлжин үсэг нь хэрэглэгдэх явцдаа нэгэнтээ урлагийн шинж чанартай байсан байна. Жишээлбэл: Юань гүрний цэргийн зарлигийн пайз, хааны зарлигийн пайз, мөнгөн гүйлгээний зоос зэргээс харж болно. Эдгээр үсгийн зарим нь төв бичлэгийн дүрмээр сийлж бичиж зарим нь урлагийн хэлбэртэй эвхмэл (гор үсэг) болсон байна. Мөн Ойрдоос дамжиж монгол үсэг үүсэх анхны үе ба хувьслын явцад олон зүйлийн өвөрмөц тодорхой онцлогтой үсэг илэрснийг үзэж болно.

-Үүнд зарим нь төв тэгш хичээнгүй тэг, хөндий тэг, татмал тэг, бичмэл тэг, жишүү тэг, цэцгэн тэг зэрэг олон төрлийн тэгтэй байдаг. Үүнээс үзэхэд ямар ч үсэг тэг нь гоо сайхны урлагийн чанарыг агуулж байдгийг илтгэж байна.

-Монгол үсэг нь үүссэнээсээ хойш хөгжиж дүрэмжих явцдаа засал чимэглэл, дүрс хуваарилалтыг тусгаж шингээсэн байна. Энэ нь Монгол үсгийн өвөрмөц бичлэгийн арга ба бүтцийн хэлбэрээс болсон гэж таамаглаж болно. Үүнд:

1. Бичиглэлд дээд үеүд нь хувилбарт тэмдгийн тусламжаар нийлэмж сайтай бөгөөд авцалдсан байдаг
2. Бичигдсэн зүйлс нь авцалдаа сайтай учраас үзэмж сайтай байдаг.
3. “Холбон бичихэд нийлэмж сайтай байдгаас бичихэд ялгуун тааламжтай байдаг ба энэхүү үсэг бичиг нь бүхлээрээ нэгэн зүйлийн урлагийн бүтээл болно” (Рун В. Г, 2012, х.3).

Уламжлалт монгол үсэг нь бий болж, дэлгэрэн хэрэглэгдсэний дараа бичиг үсэг хэрэглэгчид үсэгтээ чимэглэл гоёлын ажил хийж эхэлсэн байдаг. Жишээ нь:

1. Бүтэц: Энэ нь тод, бичлэгийн соёлын дээр, бичлэгийг тэг хэрэглэсэн багаж хэрэгслийн онцлогийг харуулж, үндэстний тод бичлэгийн тэгд зохих хэмжээний шинэлэг тал оруулснаар уншигч үзэгчдийн сонирхлын урам, магтаалыг

татсан үсэг зохиосон байна. Энэхүү үгийг утга санаатай нь уялдуулж, урлаг хэлбэрт оруулан бичсэнийг дор жишээ болгон орууллаа.

#### Зураг 7

“Өлзий” Үүлэн хээт эвхмэл үсэг




Эх сурвалж: *(The Mongolian Calligraphy 1 . Батбаяр Жалайр, 2015, х.194).*

2. Байршил: он цагт тулгарсан бичлэгийн хүрээ хэмжээний байдалд зориулж урлагжуулах зорилготой үсгийн хувирал. Энэ нь монгол үсгийн хувирах болон гоо сайхны олон талт чанарыг тусгасан бүрэн илэрхийлэл юм.

#### Зураг 8

“Монгол бичиг” дүрст эвхмэл урлаг үсэг



Эх сурвалж: *The Mongolian Calligraphy 1, Батбаяр Жалайр, 2015, х.202*

3. Бичлэг зурлага: Монгол үсгийн бичлэг зурлагт өвөрмөц дүрсийг үндэслэн сэтгэхүйн үүднээс ямар нэгэн уран санааны хэмжээсийг илтгэн ангилсан судалбар. Энэ нь монгол үндэстний амьдралд зохицсон монгол үндэстний уран сэтгэлгээг харуулж, үсэг бичлэгтээ сонирхолтой өнгө төрх оруулдаг болохыг илтгэсэн байна.

#### Зураг 9

“Гутал” монгол эвхмэл бичиг (Чимидсэнгэ, 1968 он)




Эх сурвалж: *The Mongolian Calligraphy 1, Батбаяр Жалайр, 2015, х.203*

4. Үсгийн агуулга: Монгол үндэстний бичиг нь үүссэн цагаасаа эхлэн амьдралын бодит байдлыг илтгэж, урлаг, амьдралаас шинжлэх ухааны жам ёсыг эрхэмлэж байдаг онцлогтой. Хэрэглэгчид монгол үсгийн ямар нэг давуу талыг ашиглаж, сэтгэхүйд зохицуулсан урлаг бичгийг бүтээж байдаг.

#### Зураг 10

“Монгол” эвхмэл үсэг .( Бямбын Ринчен)



Эх сурвалж: *The Mongolian Calligraphy 1, Батбаяр Жалайр, 2015, х.196*

Одоо үед монгол үсгийг ард түмэн урлагийн бүтээл хэлбэрээр өргөнөөр хэрэглэх болжээ. Иймээс нэлээд өндөр түвшинд буюу барилга, шуумал, интерьер дизайнаас гадна ахуйн хүрээнд хувцасны шошго дахь хэрэглэл, лого, зарлагын хуудас чимэгт өргөн хэрэглэж байна.

#### Зураг 11

“Монгол бичиг” Үсэн бийрээр бичсэн уран бичлэг



Эх сурвалж: [https://mn.wikipedia.org/wiki/Монгол\\_цахим\\_хуудас](https://mn.wikipedia.org/wiki/Монгол_цахим_хуудас)

Эдгээрээс үзэхэд монгол үсэг нь ихэнхдээ ард түмний амьдралд гүн нэвтэрч дан ганц ярианы тэмдэг ба солилцооны дөхөм үйлдлээс өргөн хүрээг хамарсан олон утга санааг илэрхийлсэн шинэ ухагдахуун болжээ.

**Монгол үсгийн дүр, дүрсийг дүрэмчлэхийн ач холбогдол**

-Үсэг бичиг бол хүн төрөлхтний үг хэллэгийг тэмдэглэдэг тэмдэгтэй систем болно. Ямарваа авиа

ба утгыг илтгэсэн үсэг бичиг нь бүх мэдээллийн гол зууч юм.

Урлаг үсгийн ухагдахуун бол язгуурын уламжлалт үсэг бичгийн дунд бүтээлч санааг шинээр нэмж, угийн язгуур үсгийг онцгой чанаржуулж, үсгийн тэгд гоёл ба чимэглэлийн үйлдэл хийдэг. Өнөөгийн нийгмийн хэрэгцээний хувьд авч үзвэл урлаг үсгийг 2 төрөлд хуваадаг. Үүнд:

1-р төрөл: электроны систем ба хэвлэлийн системд хэрэглэгддэг

2-р төрөл: зорилго чанар тодорхой байдаг график дизайны хүрээнд хэрэглэгддэг. Дээрх 2 төрлийг харьцуулж үзвэл 1-рт электрон систем ба хэвлэлийн системд ашигладаг урлаг үсгийн гоёл чимэглэлийн бүрэлдэхүүн нь харьцангуй цөөхөн байна.

Харин график дизайны хүрээнд хэрэглэдэг урлаг үсэг нь хэрэгцээний орчин, ахуй нь адил бусаас зохиогч нь зурж төлөвлөхдөө утга санааны агуулгыг эрхэмлэхийн хамт мөн хараа сэрлийн нөлөөлөх хүчийг тусгадаг.

Урлаг үсгийн дүр дүрсийг төлөвлөх нь бас дизайны нэг төрөл болохыг дээр дурдсан билээ. Иймээс ч үсэг бичгийн зурж төлөвлөх бол урлагийн бүтээлийн хэлбэр хэмжээ болно.

-Урлагийг бүтээхийн үндэс нь зохион бүтээх чанарын эрх чөлөөний хэмжээ юм. Үсэг бичгийг бүтээхэд ч мөн энэхүү ёсыг баримталдаг.

Хэдийгээр үсэг бичигт бүтээлч чанартай гоёл чимэглэл хийхэд тогтсон зуршлыг эвдсэн арга барилыг авах зарим тохиолдол зайлшгүй байдаг боловч урлаг үсгийн дүр дүрсийг бүтээхдээ тогтсон дүрмээ алдвал тэр нь урлагт үсгийн оршин байх давуу тал буюу утга санаагаа алддаг гэдгийг анхаарах шаардлагатай байна.

-Урлаг үсгийн дүр дүрсийг зурж төлөвлөх нь нэг зүйлийн урлагийг бүтээх хөдөлгөөн гэж тайлбарлаж болно. Тиймээс урлагийн хөдөлгөөний мөн чанар нь хүн төрөлхтөн-нийгмийн гэсэн үйлдлийн хөдөлгөөнд хамаарагддаг. Нийгмийн дэвшил хөдөлгөөний нэгэн хэсэг болсны хувьд энэхүү урлагийн хөдөлгөөн нь заавал тодорхой журам, дүрмийг баримтлах ёстой.

Дүрэмчлэх чанарын ухагдахууныг боловсролын тогтолцоо буюу оролдлогоор нэрлэхийн баримжаа гэж ойлгож байгаа юм. Өөрөөр хэлбэл боловсролын тогтсон дүрмийн шаардлагаар ажиллаж тухайн үйл явдал, хөдөлгөөн нь тодорхой хүрээнд тохирох ба хүрээнээс халихгүй байх явдал юм.

Хэдийгээр урлагийн бүтээлийг нийгмийн хөгжил, хөдөлгөөнд нийцүүлэн заавал нэг журамд нийцүүлэх нь боломжгүй боловч зарим онцгой урлагийн бүтээл бүтэх үйл нь ямар нэгэн баримжааны шаардлагад хязгаарлагддаг байна. Баримжаа тогтоох буюу нэгдсэн дүрэм, журамд

оруулахын үндсэн зорилго нь урлаг бүтээх үйл явцын эрх чөлөөг хязгаарлах биш харин тэрхүү бүтээл нь нийгэмд хялбар хүлээн зөвшөөрөгдөхийн төлөө юм. Аливаа үндэсний хэрэглэж байгаа үсэг, урлаг үсгийн дүр төрхийг зурж төлөвлөх зүйлийг үндсэндээ:

1. Гоо сайхны

2. Хэрэглээний зүй гэж үндсэн хоёр 2 хуваадаг.

Гоо сайхны зүйд нийцсэн дүрэм, журам нь нийгэмд харьцангуй хялбар ойлгогддог. Гол нь үйл ажиллагаандаа зөвхөн гоо сайхны чанарыг баримтлахыг хэлнэ. Иймээс зурж төлөвлөсөн бүтээлийн дүр дүрс нь хосгүй байна. Гоо сайхны хүрээнд агуулга ба хэлбэрийг дээд хэмжээний нэгдмэл байхыг шаардана.

Үсгэн урлагийн бүтээл нь хүний мэдрэхүйд шууд хүрч, гоо сайхны мэдрэмжтэй хамт зөв оновчтой утга санааг илтгэсэн шилдэг бүтээл гэж хэлж болно. Үүнийг хангах нь уран бүтээлчийн заавал биелүүлэх шаардлага гэж үзэж болно.

Хэрэглээний гоо зүй нь дээд хэмжээний уншигдах, ялгагдахад үндэслэгдэнэ. Учир нь үсэг бичгийн чадвар нь хүн төрөлхтний хоорондоо харилцах харилцааг бий болгох явдалд байдаг. Хэрвээ үсгэн урлагийн үсгийн дүр дүрс нь эрхэм гоёмсог байсан ч дотоод агуулга нь хүмүүст уншигдаж танигдахгүй бол энэхүү үсэг бичгийн бүтээл нь бүтээл биш болж, өөрийн утгаа алдаж хамгийн хялбар зураг дүрс, хээ угалзын бүтээл болдог.

Үсгэн бичиг үйлдэхийн хувьд үсэг бичигт чимэглэл хийх ба хувиралт оруулах нь хялбар боловч үсгийг мөн чанарыг үлдээх нь хэцүү байдаг. Гагцхүү үсгээ цоо шинэ, эрхэм гоёмсог гадаад хэлбэр дүрстэй байлгахад гадна үсгийн дуу авиаг дамжуулах үйлдлийг эвдэхгүй байвал сая амжилттай бүтээл болдог гэж үзэж болно.

Монгол үсэг бол нэгэн зүйлийн авианы үсэг юм. Түүний цагаан толгойн авиалга ба бичлэгийн дүрэм нь маш олон хувилбартай байдаг. Бичлэгийн хэлбэрээс үзвэл адил бус дуудлагатай үсгүүдийг холбон бичиж бүрэн бүтэн өгүүлбэр болгодог. Монгол үсгийн авианы бичих дүрэм нь нэлээд түвэгтэй байдаг. Хамгийн илэрхий онцлог бол адил нэгэн үсэг нь үсгийн эхэнд, үсгийн дунд, үгийн сүүлд хэрэглэхэд их хувирдаг.

Үүнээс гадна монгол үсгийн дүрэмд зарим нэгэн тусдаа үгийг хооронд нь холбож бичиж болдог. Холбон бичсэн үг нь хэдийгээр бичлэг нь хувирсан боловч утга санаа нь хувирдаггүй. Жишээлбэл: Баяр-Сайхан, Тунгалаг-Тамир гэх мэт.

Иймэрхүү монгол үсгийн өвөрмөц бөгөөд түвэгтэй авиалах, унших, бичих арга нь урлаг үсэгт чимэглэл, гоёл хийхэд нэн ялангуяа дүрсийг

чухалчилж үзэхэд чухал хэрэгтэй. Монгол үсгийн үндсэн хэлбэрийг үлдээж, дуу авиа уламжлах, мэдээ мэдээлэл зуучлах чадварыг утгаар нь байлгахын тулд харааны сэрлийн гоо сайхны зүйд ч нийцэх зорилгыг мөн тусгаж байх нь зүйтэй юм.

## Дүгнэлт

1. Аливаа улс үндэстний бичиг үсэг нь тухайн хэлээр харилцагч ард түмний нийтлэг онцлогийг адилхан харуулахын хажуугаар, нутаг нутгийн хэл ярианы байдлыг эрх тэгш анхаарсны улмаас нийтээр хэрэглэх боломжтой болж, тухайн ард түмнийг бичиг үсгээр нь дамжуулан хэлний хувьд нэгтгэж байдаг. Тиймээс уйгаржин монгол үсэг нь аль нэг ноёрхох аялгууг бусад олон аялгуунд хүчээр тулгаагүй, олон үндэстэн ястны хэлний онцлогийг жигд тусгасан бичиг үсэг юм.
2. Монголчууд түүхэн хөгжлийн явцдаа маш олон бичиг үсэг зохион хэрэглэж ирсэн, бичиг үсгийн өндөр соёлтой ард түмэн боловч эдгээр бичиг үсгээс монгол туургатны орон зайд, нэгдмэлээр хамгийн удаан жигд хэрэглэгдэж, оршин тогтносоор ирсэн үсэг бол уйгаржин монгол үсэг гэж үзлээ.
3. Монгол үсгийн дүрсийг дүрэмчлэхдээ гоо сайхны болон хэрэглээний зорилгыг баримталж ирсэн байна.
4. Бичиг үсгийн гоо сайхан дүрслэлээс гадна график дизайны нарийн шийдлийг тусгасан, өвөрмөц онцлогийг агуулж байдаг.
5. Мөн монгол үгийн яруу тансаг утгыг бүрэн төгс илэрхийлж байдаг өв их эрдэнэ болсон бичиг үсэг юм.

## Ашигласан материал

БатбаярЖалайр, Д. (2015).

The Mongolian Calligraphy 1.

Улаанбаатар.

Ван гүй рунг (2012). Монгол бичг үсгийн бүтцийн судалгаа. Леонинийн үндэстний хэвлэлийн хороо. Дамдинсүрэн.А. (1986). Монголын дөрвөлжин бичиг. Улаанбаатар.

<https://mn.wikipedia.org/wiki/Монгол>, цахим хуудас

<http://www.munkho.de/wp/монгол-бичгийн-соёл-түүх-уран-бичлэг-6-2/>